

2020 оны-р сарын-ны өдөр

**СЭЛЭНГЭ АЙМАГТ 2020 ОНЫ 01 ДҮГЭЭР САРД ЗОХИОН БАЙГУУЛАХ
НЭГДСЭН АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Хийгдэх ажил, арга хэмжээ	Хугацаа	Хэрэгжүүлэх хэлтэс, алба, газар	Хариуцах эзэн
Нэг.Удирдлага зохион байгуулалтын хүрээнд				
1	Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр хэрэгжилт, явц үр дүнгийн талаар иргэд олон нийтэд мэдээлэл өгөх, иргэдийн санал, өргөдөл, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх зорилгоор Сайхан, Сант, Орхон сум, Номгон тосгонд ажлын хэсгийг ажиллуулах	1 дүгээр сарын 16-20	Аймгийн Засаг даргын Тамгын газар	Ө.Сувдаа
2	Монгол Улсын Их Хурал, Засгийн газрын тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн болон 2019 оны санал, өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн тайланг гаргаж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэх	1 дүгээр сарын 10-15	Төрийн захиргааны удирдлагын хэлтэс	Б.Болорзул
3	Төрийн албаны салбар зөвлөлийн 2019 оны үйл ажиллагааны тайлан, төрийн албан хаагчдын бүрэлдэхүүн, хөдөлгөөний мэдээг гарган Төрийн албаны зөвлөлд хүргүүлэх.	Сардаа	Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөл	Ө.Сувдаа
4	Удирдлагын академитай хамтран “Нутгийн захиргааны байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөлт” сургалтад аймаг, сумын Засаг даргын Тамгын газрын болон аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний зарим агентлагийн холбогдох мэргэжилтнүүдийг хамруулах	1-р сарын 16-17	Аймгийн Засаг даргын Тамгын газар	Ө.Сувдаа
5	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга, аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргын сонгон шалгаруулалтыг зохион байгуулах	1 дүгээр сарын 7-9	Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөл	Ө.Сувдаа
6	“Төрийн үйлчилгээний байгууллагын төсвийн шууд	1 дүгээр	Төрийн албаны	Ө.Сувдаа

	захирагчийгсонгон шалгаруулах журам”-д заасны дагуу Хушаат, Сайхан сумын ерөнхий боловсролын 2 дугаар, Номгон тосгоны сургуулийн захирал, Ерөө сумын 1 дүгээр, Алтанбулаг сумын 3 дугаар цэцэрлэгийн эрхлэгчийн албан тушаалын сонгон шалгаруулалтыг зохион байгуулах	сарын 7-10	зөвлөлийн салбар зөвлөл	
7	МУ-ын Үндсэн хуулийн 28 жилийн ойн өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх ажлыг зохион байгуулах	1 дүгээр сарын 13	Хууль, эрх зүйн хэлтэс	Д.Ёндонжамц
8	“Шүүхийн шинжилгээний байгууллагын үйл ажиллагаа”, “Шинжээч томилсон тогтоол, дүгнэлттэй холбоотой гарч байгаа хүндрэл бэрхшээл, цаашид анхаарах асуудал сэдэвт хамтарсан зөвлөгөөнийг Мандал, Сайхан сумдад холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулах	1 дүгээр сарын 01-14	Хууль, эрх зүйн хэлтэс, Мандал, Сайхан сумын прокурорын газар, Шүүхийн шинжилгээний алба, Цагдаагийн хэлтэс	Д.Ёндонжамц
9	ХАСХОМ мэдүүлэг гаргагчдын нэрсийн жагсаалтыг аймгийн хэмжээнд нэгтгэн гаргаж Авлигатай тэмцэх газарт хүргүүлэх	1 дүгээр сарын 10	Хууль, эрх зүйн хэлтэс	Д.Ёндонжамц
10	2020 оны цэргийн бүртгэлийг зохион байгуулж, дүн мэдээг Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний Жанжин штабт хүргүүлэх	Сардаа	Цэргийн штаб	Б.Энхболд
11	Сэлэнгэ аймгийн 2019 оны жилийн эцсийн нийгэм, эдийн засгийн танилцуулга гаргах, тархаах	1 дүгээр сарын 15-ны дотор	Статистикийн хэлтэс	Д.Гүндэгмаа
12	Хүн ам, орон сууцны тооллогын мэдээлэл цуглуулалтанд ажиллах тооллогч нарт сургалт байгуулж, 2020 оны улсын ээлжит тооллогыг зохион байгуулах	1 дүгээр сарын 4-15ны өдрүүдэд	Статистикийн хэлтэс, Аймаг, сумын тооллогын комисс,	Д.Гүндэгмаа
Хоёр.Нийгмийн салбарын хүрээнд				
1	ЕБС-ийн 5 дугаар ангийн багш нар, 9, 12 дугаар ангид физик, хими, гадаад хэл, математик, монгол хэл бичиг, уран зохиол, нийгмийн ухааны хичээлийн багш нарт зориулсан сургалтыг зохион байгуулах	Сардаа	Боловсрол, соёл, урлагийн газар	Ч.Жаргалсайхан
2	“Орон зайнаас үл хамааран суралцъя, ажиллая” төслийн танилцуулга, бага боловсролын сургалтын менежерийг чадваржуулах сургалтыг зохион байгуулах	Сардаа	Боловсрол, соёл, урлагийн газар	Ч.Жаргалсайхан
3	Орхон бүсийн сумдад зөвлөн туслах үйл ажиллагааг зохион байгуулах	Сардаа	Боловсрол, соёл, урлагийн газар	Ч.Жаргалсайхан

4	Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийн байдалд явцын үнэлгээ хийх	Сардаа	Эрүүл мэндийн газар	Ж.Од
5	Халдварт болон халдварт бус өвчнийг эрт илрүүлэх цогц үзлэгийг Мандал суманд зохион байгуулах	Сардаа	Эрүүл мэндийн газар	Ж.Од
6	Өрхийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэлтэй бүх хүүхдэд хүүхдийн мөнгөн тэтгэмж олгох ажлыг зохион байгуулах	Сардаа	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар	Л.Зоригтбаатар
7	Аймгийн аварга шалгаруулах “Цодгор хүү” өсвөрийн шатарчдын уралдааныг зохион байгуулах.	Сардаа	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар	П.Оюун
8	Футзал, сагсан бөмбөг, волейболын өсвөр үеийн аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг тус тус зохион байгуулах	Сардаа	Биеийн тамир, спортын газар	
Гурав.Хөгжлийн бодлогын хүрээнд				
1	Мал үржлийн албаны 2019 оны жилийн эцсийн тайланг гарган холбогдох газруудад хүргүүлэх	Сардаа	Хүнс, хөдөө аж ахуйн газар	Б.Мөнхтөр
2	Сумдаас улаанбуудайн урамшууллын материалыг хүлээн авч Хүнс, Хөдөө аж ахуйн хөнгөн үйлдвэрийн яаманд хүргүүлэх	Сардаа	Хүнс, хөдөө аж ахуйн газар	Б.Мөнхтөр

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР